



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/199

Хэрлэн сум

Салбар зөвлөл байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоол, Шадар сайдын 2023 оны 12 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дэргэд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах Байнгын ажиллагаатай салбар зөвлөл”-ийг байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр, салбар зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 31-ны өдрийн
А/199/2023 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
“Хэнтий-Ус” ТӨХК-ийн захирал
Автотээврийн төвийн дарга
Хэрлэн сумын Засаг дарга
Бор-Өндөр сумын Засаг дарга
“Харгуй” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга
Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Байнгын ажиллагаатай салбар зөвлөл /цаашид "салбар зөвлөл" гэх/ нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн Засаг дарга баталж, үйл ажиллагаа, үүрэг даалгавар, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.

2.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын явцтай танилцаж шийдвэр гаргана.

2.3. Салбар зөвлөл нь дарга, орлогч, гишүүд, нарийн бичгийн даргатай байна.

2.4. Салбар зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг орлогч дарга гүйцэтгэнэ.

2.5. Салбар зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ажлын шаардлагаар ээлжит бусаар хуралдаж болно.

2.6. Хэлэлцэх асуудлаас хамааран салбар зөвлөлийн хуралд холбогдох албан тушаалтаныг оролцуулж, өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно.

2.7. Салбар зөвлөлийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.8. Салбар зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж албажуулна.

2.9. Салбар зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байх бөгөөд хэвлэмэл хуудас, тэмдэгийг Ажлын алба хариуцна.

2.10. Салбар зөвлөлийн Ажлын албаны үүргийг Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын Бүсийн шуурхай удирдлага, зарлан мэдээлэх тасаг гүйцэтгэнэ.

2.11. Салбар зөвлөл шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.12. Хүчтэй газар хөдлөлт хот, суурин газар болсон үед салбар зөвлөлийн бүрэлдэхүүн дуудлага, зарлалгүйгээр аймгийн Онцгой байдлын газар, эсхүл аймгийн Засаг дарга, Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн даргын заасан газарт цугларна.

2.13. Салбар зөвлөл ажлаа Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай дэд зөвлөл, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд танилцуулна.

Гурав. Салбар зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Байнгын ажиллагаатай салбар зөвлөл дараах эрхтэй байна.

3.1.1. Салбар зөвлөл нь үйл ажиллагааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт, албан даалгавар, зөвлөмж гаргана.

3.1.2. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, яам, агентлаг, төрийн байгууллага, хуулийн этгээдийн тайлан, мэдээллийг сонсож, дүгнэлт гаргах, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, хяналт тавих,

3.1.3. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлага тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж, шийдвэр гарган биелүүлэхийг шаардах,

3.1.4. Салбар зөвлөл нь газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлын үндсэн чиглэл, шаардагдах хөрөнгө, гарсан үр дүн, бэлэн байдлын түвшин зэргийг хэлэлцэж үүрэг чиглэл өгөх,

3.1.5. Төрийн болон төрийн бус байгууллага, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангиудын газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг тодотгох, нэмэлт өөрчлөлт оруулах, гамшгаас хамгаалах, сэргийлэх арга хэмжээний чиглэл тогтоох, бэлэн байдлыг хангуулах,

3.1.6. Газар хөдлөлтийн бүс дэх барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил, комисст хүлээн авах, хяналт болон стандарт, норм, дүрмийн шинэчлэлийн талаарх мэдээлэл солилцох, хот төлөвлөлт, аюулгүй байдлын талаарх асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах;

3.2. Салбар зөвлөл дараах үүрэгтэй байна.

3.2.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах,

3.2.2. Монгол Улсын Засгийн газар, Байнгын ажиллагаатай дэд зөвлөл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж ажиллах,

3.2.3. газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах анхааруулга, санамж, зөвлөмж болон авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх,

3.2.4. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны талаар хийсэн ажлаа Байнгын ажиллагаатай дэд зөвлөл, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд тайлагнах,

3.2.5 Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах асуудлаар гадаад улс орон, олон улсын болон ижил төсөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцах, хамтран ажиллах, туршлага судлах,

Дөрөв. Салбар зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1. Салбар зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;

4.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, гишүүдэд үүрэг чиглэл өгч, биелэлтэд хяналт тавих;

4.3. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагааны талаар дээд шатны байгууллага (Шадар сайд, дэд зөвлөл, ГЭБОНЗ, АОК)-д танилцуулах;

4.4. Салбар зөвлөлийн хурлыг таслах, хоцрох, зөвлөлийн шийдвэр, төлөвлөгөөний хүрээнд хариуцсан ажлаа тасалдуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох талаар дээд шатны байгууллагад мэдэгдэх, хэрэгжилтэд хяналт тавих.

Тав. Салбар зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

5.1. Салбар зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна. Үүнд:

5.1.1. Өөрийн хариуцсан чиглэлийн хүрээнд зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар дэд зөвлөл болон холбогдох яам, агентлаг, хуулийн этгээдээс мэдээлэл авах, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих;

5.1.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой санал гаргах;

5.1.3. салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах, хэлэлцүүлэх, тайлагнах;

5.1.4. Салбар зөвлөлийн төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

5.1.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд урьдчилан мэдэгдэх, хэлэлцэх асуудлын талаарх саналаа бичгээр хүргүүлэх;

5.1.6. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргатай үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;

5.2. Салбар зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна. Үүнд:

5.2.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, түүнд шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх;

5.2.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хуралдаанд идэвх санаачлагатай оролцох;

5.2.3. Салбар зөвлөлийн даргын баталсан төлөвлөгөө, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг салбар зөвлөлийн даргад тайлагнах;

5.2.4. Салбар зөвлөлийн гишүүд нь шаардлагатай тохиолдолд өөрийгөө орлох албан тушаалтныг томилж, тухайн албан тушаалтны нэр, холбогдох утас, цахим хаягийг Ажлын албанд албан бичгээр өгөх, өөрчлөлт орох тухай бүр шинэчлэн мэдэгдэж байх.

Зургаа. Салбар зөвлөлийн Ажлын албаны эрх, үүрэг

6.1. Салбар зөвлөлийн Ажлын алба нь Байнгын ажиллагаатай салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг сайжруулах ажлыг аймгийн хэмжээнд чиглүүлэх, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлж, үр дүнг тооцож ажиллана.

6.2. Салбар зөвлөлийн зохион байгуулсан ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил зохион байгуулна.

Долоо. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

7.1. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрхтэй. Үүнд:

7.1.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөлийн гишүүд, холбогдох яам, агентлаг, төрийн байгууллага, хуулийн этгээдээс мэдээлэл авах, зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

7.1.2. Салбар зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зөвлөлийн гишүүдээс дэмжлэг авах, төлөвлөгөөний төслийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах;

7.1.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгаа, төслийн баримт бичиг, холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

7.2. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэгтэй. Үүнд:

7.2.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, хөтөлбөрийг салбар зөвлөлийн даргаар батлуулах;

7.2.2. Хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад мэдэгдэх, хуралдааны ирцийг бүрдүүлэх;

7.2.3. Салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгах санал авч боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.2.4. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайланг холбогдох байгууллагаас гаргуулах, нэгтгэн зөвлөлийн хуралдаанд танилцуулах, зөвлөлийн баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөх;

7.2.5. Галбар зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог хангах;

7.2.6. Салбар зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, зохион байгуулалтын зардлын тооцоог зөвлөлийн даргад танилцуулж, шийдвэрлүүлэх;

7.2.7. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж танилцуулах, зохион байгуулсан ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлах ажил зохион байгуулах.

Найм. Салбар зөвлөлийн ажиллах журамд
нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Салбар зөвлөлийн гишүүд салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргана.

8.2. Салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэн салбар зөвлөлийн дарга батална.